**ХӨВСГӨЛ АЙМГИЙН**
**ЧАНДМАНЬ-ӨНДӨР СУМЫН ЗАСАГ ДАРГЫН**
**ЗАХИРАМЖ**

2024 оны 04 сарын 25 өдөр　　　　Дугаар А/30　　　　Хөхөө

Төлөвлөгөө батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 59.1.1, 66 дугаар зүйлийн 66.1, Авлигын эсрэг хуулийн 6 дугаар зүйл, Монгол Улсын Их Хурлын 2023 оны 59 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх "Авлигын эсрэг үйл ажиллагааны 2024 оны ажлын төлөвлөгөө"-г хавсралтаар баталсугай.

2.Энэхүү захирамжаар батлагдсан төлөвлөгөөний хэрэгжилтийг ханган ажиллаж, хагас жилийн тайланг 2024 оны 06 дугаар сарын 01-ны дотор, бүтэн жилийн тайланг 2024 оны 12 дугаар сарын 01-ны дотор Засаг даргын Тамгын газарт ирүүлж ажиллахыг албан байгууллагын дарга эрхлэгч нарт үүрэг болгосугай.

3.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хууль эрх зүйн мэргэжилтэн (Б.Баярцэцэг )-д даалгасугай.

ДАРГА　　　　Л.ЭНХЖАРГАЛ

C My Documendts-2024-CZD-ZAHIRAMJ-A

670800100089

Сумын Засаг даргын 2024 оны 04 дүгээр сарын 25-ны өдрийн А/30 дугаар захирамжийн хавсралт

# ЧАНДМАНЬ-ӨНДӨР СУМЫН 2024 ОНЫ АВЛИГЫН ЭСРЭГ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ

2024 оны 04 дүгээр сарын 25

| Зорилт | Арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Хөтөө: Хүрэх түвшин, үр дүн | Хөтөө: Хариуцах эзэн |
|---|---|---|---|---|
| 1. Авлигын эсрэг хууль тогтоомжийг иргэдэд сурталчлах, соён гэгээрүүлэх үйл ажиллагааны хүртээмжийг нэмэгдүүлэх | 1.1. Авлигатай тэмцэх газраас соён гэгээрүүлэх чиглэлээр бэлтгэсэн контентуудыг а/байгууллагын албан ёсны цахим хуудас; б/сошиал сувгууд; в/дотоод сүлжээ; г/хэвлэл мэдээллийн хэрэгсэл, д/мэдээлэл сурталчилгаа самбар, лед дэлгэц, е/бусад (салбар байгууллагууд) хэлбэрээр сурталчилж, олон нийтэд хүргэх | Тогтмол шинэчлэн, тогтвортой байршуулсан байх, түгээсэн, хүрсэн үр дүнгийн талаар салбар хариуцсан ажилтанд тухай бүрд тайлагнадаг байх, Харьяа нэгжүүдийг нэгэн зэрэг хамруулж, үр дүнг нэгтгэн тайлагнаж хэвших, Тайланд холбогдох нотломжийг хавсаргаж хэвших. | Контентуудыг албан ёсны цахим хуудас, сошиал сувгууд, дотоод сүлжээ, хэвлэл мэдээллийн хэрэгсэл бусад хэлбэрээр сурталчилж ажилласан байна. | ХЭЗХМ Б.Баярцэцэг Албан байгууллагын дарга эрхлэгч нар |
| | 1.2. Өөрийн байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохируулан иргэд, олон нийтэд чиглэсэн соён гэгээрүүлэх нээлттэй хаалганы өдөрлөг, арга хэмжээг зохион байгуулах | Өдөрлөг оролцсон иргэдээс байгууллагын үйл ажиллагаа, үйлчилгээтэй холбоотой санал хүсэлт авч, түүнд үндэслэн арга хэмжээг хэрэгжүүлсэн байх, Авлигатай тэмцэх газраас өрнүүлж буй аян, уриалгатай уялдсан байх, Үр дүнг тооцсон байх. | Өөрийн байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон нээлттэй хаалганы өдөрлөг, арга хэмжээг зохион байгуулсан байна. | ЗДТГ-ын дарга Ж.Баасанжав ХЭЗХМ Б.Баярцэцэг, ЭБАТ Б.Азжаргал Албан байгууллагын дарга эрхлэгч нар |
| | 1.3. Өөрийн байгууллагын эрх хэмжээ, үйл ажиллагаатай холбогдуулан эрхлэн гаргадаг ном, гарын авлага, сэтгүүл, иргэдэд тараадаг хэвлэмэл материал, | Мэдээллийг Авлигатай тэмцэх газраас буюу баталгаат эх сурвалжаас авсан байх, Байгууллагын эрх хэмжээний хүрээнд иргэд, олон нийт рүү | Ном, гарын авлага, сэтгүүл, иргэдэд тараадаг хэвлэмэл материал, зэрэгт | ЗДТГ-ын дарга Ж.Баасанжав |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | зэрэгт авлигын хор хөнөөлийг иргэдэд ойлгуулах, "Шүгэл" үлээхийг сурталчлан таниулсан түүнд уриалсан мэдээлэл болон авлигыг мэдээлэх "110" дугаарыг оруулан сурталчлах. | чиглэсэн хэвлэмэл материалд оруулсан байх, Үр дүнг нэгтгэн тайлагнасан байх, Тайланд холбогдох нотломжийг хавсаргаж хэвших. | авлигын хор хөнөөлийг иргэдэд ойлгуулах, шүгэл үлээхийг сурталчлан таниулсан, түүнд уриалсан мэдээлэл болон авлигын мэдээлэх "110" дугаарыг оруулан сурталчлан ажилласан байна. | ХЭЗХМ Б.Баярцэцэг Албан байгууллагын дарга эрхлэгч нар |
| | 1.4. Өөрсдийн байгууллагын үйл ажиллагаанд авлигад өртөж болзошгүй чиглэлийг сонгон авлигын эрсдэлээс ангид байхад чиглэсэн, ёс зүй, шударга байдлыг уриалсан агуулга бүхий 2-оос доошгүй видео контент бүтээж, олон нийтэд хүргэсэн байх | Авлигын эрсдэлээс урьдчилан сэргийлэхэд чиглэсэн байх, Авлигын мэдээлэх 110 дугаарын утсыг сурталчилсан байх, Олон нийтэд түгээсэн байх. | Ёс зүй, шударга байдлыг уриалсан агуулга бүхий видео контент бүтээж, олон нийтэд хүргэсэн байна | ЗДТГ-ын дарга Ж.Баасанжав, ЭБАТ Б.Азжаргал ХЭЗХМ Б.Баярцэцэг Албан байгууллагын дарга эрхлэгч нар |
| 2. Ил тод байдлыг сайжруулах, хүнд суртал, чирэгдлийн бууруулах, олон нийтийн хяналтыг хэрэгжүүлэх | 2.1. "Төрийн байгууллага, албан тушаалтны үйл ажиллагаанд олон нийтийн хяналтыг хэрэгжүүлэх журам"-ыг хэрэгжүүлэх | Журамд заасны дагуу өөрийн байгууллагын үйл ажиллагааны 1-ээс доошгүй чиглэлд олон нийтийн хяналтыг хэрэгжүүлэхээр тусгасан байх, сонгосон чиглэлд олон нийтийн хяналтыг хэрэгжүүлэх сонгон шалгаруулалт зарласан байх, олон нийтийн хяналтыг хэрэгжүүлэн тайлагнах, үр дүнд суурилсан арга хэмжээ зохион байгуулсан байх | Олон нийтийн хяналтын журмыг хэрэгжүүлж ажилласан байна. | ЗДТГ-ын дарга Ж.Баасанжав, САД Д.Болд-Эрдэнэ ХЭЗХМ Б.Баярцэцэг Албан байгууллагын дарга эрхлэгч нар |
| | 2.2. Авлигаас урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үйл ажиллагаанд иргэний нийгмийн оролцоо, хамтын ажиллагааг нэмэгдүүлэх | Салбар бүрт үйл ажиллагаа явуулж буй төрийн бус байгууллагуудын нэгдсэн судалгааг гаргасан байх, Авлигаас урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх чиглэлээр иргэний нийгмийн оролцоо, хамтын ажиллагааг | Иргэний нийгмийн оролцоо, хамтын ажиллагааг нэмэгдүүлж ажилласан байна. | ЗДТГ-ын дарга Ж.Баасанжав, ЭБАТ Б.Азжаргал ХЭЗХМ Б.Баярцэцэг |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | нэмэгдүүлэх чиглэлээр арга хэмжээ авсан байх, Үр дүнг тооцож, тайлагнасан байх | | Албан байгууллагын дарга эрхлэгч нар |
| | 2.3. Төсвийн хөрөнгөөр санхүүжих хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний төлөвлөлт, хэрэгжилтийн талаарх мэдээллийн нээлттэй, ил тод байдлыг нэмэгдүүлж, иргэн, иргэний нийгмийн байгууллагын оролцоог хангах | 2024 онд төсвийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний хэрэгжилтийн талаар иргэд, олон нийтэд тогтмол ойлгомжтой байдлаар тогтмол мэдээлэх, Төсвийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний хэрэгжилттэй холбоотой иргэд, олон нийтийн саналыг авч холбогдох арга хэмжээг авах, Иргэн, иргэний нийгмийн оролцоог нэмэгдүүлэх чиглэлээр арга хэмжээ хэмэгжүүлэх | Ил тод байдлыг хангаж ажилласан байна. | ЗДТГ-ын дарга Ж.Баасанжав санхүү албаны дарга Д.Болд-Эрдэнэ Албан байгууллагын дарга эрхлэгч нар |
| | 2.4. Байгууллагуудын үйл ажиллагаа, үйлчилгээний хүнд суртал чирэгдэлтэй холбоотой ирүүлсэн гомдол, мэдээлэлд дүн шинжилгээ хийж, үр дүнд суурилсан арга хэмжээг хэрэгжүүлж хэвших | Байгууллагын үйл ажиллагаа, үйлчилгээний хүнд суртал чирэгдэлтэй холбсотой гомдол, мэдээллийн судалгааг тогтмол гаргаж, тайлагнах, Хуулийн хүрээнд шуурхай, бодитой шийдвэрлэж хэвших, Иргэд, олон нийтээс Байгууллагын үйл ажиллагаа, хүнд суртал чирэгдэл, холбоотой гомдол мэдээлэлд дүн шинжилгээ хийж, үр дүнд суурилсан арга хэмжээг хэрэгжүүлэх. | Гомдол, мэдээлэлд дүн шинжилгээ хийж, үр дүнд суурилсан арга хэмжээг хэрэгжүүлж ажилласан байна. | ЗДТГ-ын дарга Ж.Баасанжав, ХЭЗХМ Б.Баярцэцэг Албан байгууллагын дарга эрхлэгч нар |
| **3. Авлига, ашиг сонирхлын зөрчил үүсгэх шалтгаан, нөхцөлийг арилгуулах арга хэмжээ** | 3.1. Авлигын эрсдэл ба авлига гарах боломжийг бууруулах чиглэлээр тухайн байгууллагаас цахимаар иргэд, олон нийтэд үзүүлж буй цахим үйлчилгээний чанар, хүртээмжийг дээшлүүлэх чиглэлээр арга хэмжээг зохион байгуулах | Нэвтрүүлсэн цахим үйлчилгээний чанар хүртээмжийн талаар иргэд, олон нийтээс судалгаа, санал асуулга авах, дүн шинжилгээ хийж, үр дүнд суурилсан арга хэмжээг хэрэгжүүлэх, хэрэгжилтийг тайлагнах. | Цахим үйлчилгээний чанар сайжирсан байна | ЗДТГ-ын дарга Ж.Баасанжав, ХЭЗХМ Б.Баярцэцэг Албан байгууллагын дарга эрхлэгч нар |
| | 3.2. Байгууллагын дотоод хяналтын механизмыг сайжруулж, албан хаагчдыг авлига, ашиг | Албан хаагчидтай холбогдуулан ирүүлсэн авлига, ашиг сонирхлын зөрчилтэй холбоотой гомдол, | | ЗДТГ-ын дарга Б. Баасансүрэн |

| | | | | |
|---|---|---|---|---|
| **авах** | сонирхлоос ангид байхад чиглэсэн арга хэмжээг хэрэгжүүлэх; | мэдээллийг Авлигатай тэмцэх газарт шилжүүлж хэвших, Албан хаагчдыг авлига, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байхад чиглэсэн арга хэмжээг байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохируулан эрсдэлийг тодорхойлсон байх, Эрсдэлийг арилгах арга хэмжээнд дотоод хяналтын үйл ажиллагааг зохион байгуулсан байх | Авлига ашиг сонирхлын зөрчлөөс ангид байхад чиглэсэн арга хэмжээг зохион байгуулж ажилласан байх | Дотоод хяналтын баг Т.Доньдмаа Албан байгууллагын дарга эрхлэгч нар |
| | 3.3. Тухайн байгууллага өөрийн үйл ажиллагааны онцлогт тохируулан авлигаас урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх чиглэлээр шинээр санал, санаачилга гарган додорхой арга хэмжээ хэрэгжүүлэх | Төлөвлөгөөний 1.1-3.2 дахь хэсэгт заасан арга хэмжээтэй агуулгаараа давхцахгүй байх, Байгууллагын үйл ажиллагаа, үзүүлж буй төрийн үйлчилгээний онцлогт тохируулан зохион байгуулсан арга хэмжээний үр дүнг олон нийтэд мэдээлсэн байх, АТГ-аас хүргүүлсэн зөвлөмж, албан бичгийн хэрэгжилтийг хангасан байх, үйлчилгээ авдаг, хамтарч ажилладаг, зорилтод бүлэгт урьдчидан сэргийлэх чиглэлээр хэрэгжүүлсэн арга хэмжээ, хийсэн өөрчлөлт, хүрсэн үр дүнгийн талаар мэдээлэл хүргэсэн байх. | Авлигаас урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх | ЗДТГ-ын дарга Ж.Баасанжав, ЭБАТ Б.Азжаргал ХЭЗХМ Б.Баярцэцэг Албан байгууллагын дарга эрхлэгч нар |

____oOo____